

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Агуулга

1	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	2
2	АУДИТЫН ТАЙЛАН	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал	10
3.2	Балансын данстай холбоотой асуудал.....	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6	Аудит хийсэн төсвийн тохируулгын тайлан.....	17
4.7	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНЧИМЭГ ТАНАА

2019.02.25 № 06/257
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Ц.Ганчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019/01/25-наас 2019/02/18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019/02/18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ын аудитор Г.Бэлэгт хариуцаж хэрэгжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д 2019/01/25-ны өдрийн 1/29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөгжлийн бодлого боловсруулах, төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах, салбар дундын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрх болон нийгмийн хамгааллын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бодлого

боловсруулах, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллагад уламжлах, төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, салбар дундын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Хөдөлмөрийн, Нийгмийн даатгалын, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, заавар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан.Тайлант онд тухайн байгууллагын мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд

шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг шууд гүйцэтгэлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн "Acolous" программ" програм хангамж ашигладаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаагаас нийт зарлагыг суурь үзүүлэлт болгосонтой холбоотой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 277949.2 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 5559.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд

тооцно гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/мянган төгрөг/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	3,356.5	
	Дүн	2	3,356.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

“УСНББОУС, Сангийн сайдын 207 дугаар тушаалаар батлагдсан журам зөрчиж, Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр Газар эзэмших/ ашиглах эрхийн үнэлгээний 62,007.7 мянган төгрөгийн дүнг биет бус хөрөнгөнд бүртгээгүй байсныг Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Арилжааны банкинд нээлгэсэ байгууллагын жижиг мөнгөн сангийн дансны үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байх шаардлагатай.Зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх. Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгиж, шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 325,149.1 мянган төгрөгийн

төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2018 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлж, төсвийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна. Тус байгууллагын ТШЗ нь 2018 онд төсвөөс урсгал зардалд 325,149.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснийг бүрэн авч, гүйцэтгэлээр 313,772.6 мянган төгрөгийг зарцуулж, 11,368.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, арилжааны банкин дахь харилцах дансанд 8.0 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 2018 оны төсвийн төлөвлөгөө, 2018 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг тухай бүр оруулж мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллага нь 2018 оны 10-р сард шинээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан учир өмнөх аудитын зөвлөмж, хэрэгжилт байхгүй болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын автомашинд авсан сэлбэгийн үнэ 606.5 мянган төгрөгийг бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн материалын зардлын дансанд бүртгэсэн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 6.3 “Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх” заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар” -ыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд зардал буруу, алдаатай илэрхийлэгдэх, холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох стандарт, хууль тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллах, Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төсвийн шууд захирагчийн зүгээс өгсөн зөвлөмжийг биелүүлж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллана гэж хариу ирүүлсэн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шатахуун худалдан авсан 2,750.0 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, бараа материалын дансанд орлого аваагүй, шууд зардлын дансанд бүртгэсэн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “ Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар” -ыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа материалын орлого, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах, Холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох стандарт, хууль тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллах, Алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Төсвийн шууд захирагчийн зүгээс өгсөн зөвлөмжийг биелүүлж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллана гэж хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	4,601,000.00
МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	8,000.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	8,000.00
Төгрөг	00.00	8,000.00
Арилжааны банк дахь харилцах	00.00	8,000.00
БАРАА МАТЕРИАЛ	00.00	4,593,000.00
Хангамжийн материал	00.00	4,593,000.00
Бичиг хэргийн материал	00.00	4,593,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	6,724,444,852.54
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	6,724,444,852.54
Биет хөрөнгө	00.00	6,656,682,152.54
Барилга, байгууламж, орон сууц	00.00	6,558,034,247.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	79,654,315.48
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-9,984,713.21
Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	32,216,056.96
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-22,777,738.68
Бусад үндсэн хөрөнгө	00.00	14,080,635.00
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,540,650.01
Ном	00.00	8,000,000.00
Биет бус хөрөнгө	00.00	67,762,700.00
Бусад биет бус хөрөнгө	00.00	67,762,700.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	00.00	6,729,045,852.54
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	00.00	6,729,045,852.54
Засгийн газрын хувь оролцоо	00.00	6,729,045,852.54
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	1,474,849,925.14
Өмч: - төрийн	00.00	1,474,849,925.14
Хуримтлагдсан үр дүн	00.00	47,199,920.46
Тайлант үеийн үр дүн	00.00	47,199,920.46
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	5,206,996,006.94
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	00.00	6,729,045,852.54

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	00.00	325,149,100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	325,149,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	325,149,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	325,149,100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	00.00	277,949,179.54
УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	277,949,179.54
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	266,580,635.11
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	83,873,925.76
Үндсэн цалин	00.00	83,873,925.76
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	9,989,754.81
Тэтгэврийн даатгал	00.00	6,812,234.14
Тэтгэмжийн даатгал	00.00	851,529.27
ҮОМШӨ-ний даатгал	00.00	681,223.41
Ажилгүйдлийн даатгал	00.00	149,524.36
Эрүүл мэндийн даатгал	00.00	1,495,243.62
Хангамж, бараа материалын зардал	00.00	36,922,207.00
Бичиг хэрэг	00.00	27,535,599.00
Тээвэр, шатахуун	00.00	2,750,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	6,636,608.00
Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	84,218,338.00
Багаж, техник, хэрэгсэл	00.00	611,350.00
Урсгал засвар	00.00	83,606,988.00
Томилолт, зочны зардал	00.00	1,732,000.00
Дотоод албан томилолт	00.00	1,732,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	32,698,420.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	30,115,600.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,582,820.00
Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,145,989.54
Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	9,510,910.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	7,635,079.54
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	11,368,544.43
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	11,368,544.43
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,368,544.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	00.00	47,199,920.46
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	00.00	47,199,920.46

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан
/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	00.00	325,149,100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	325,149,100.00
Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	325,149,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	325,149,100.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	00.00	325,141,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	325,141,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	313,772,555.57
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	83,873,925.64
Үндсэн цалин	00.00	64,812,484.64
Нэмэгдэл	00.00	9,372,593.00
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	9,688,848.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	9,989,754.93
Тэтгэврийн даатгал	00.00	9,989,754.93
Хангамж, бараа материалын зардал	00.00	44,428,057.00
Бичиг хэрэг	00.00	16,623,099.00
Тээвэр, шатахуун	00.00	2,750,000.00
Ном, хэвлэл	00.00	6,250,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	18,804,958.00
Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	107,299,488.00
Багаж, техник, хэрэгсэл	00.00	29,876,500.00
Урсгал засвар	00.00	77,422,988.00
Томилолт, зочны зардал	00.00	1,732,000.00
Дотоод албан томилолт	00.00	1,732,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	48,158,420.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	39,260,600.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	8,897,820.00
Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,290,910.00
Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,290,910.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	11,368,544.43
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	11,368,544.43
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	11,368,544.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	8,000.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	8,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	5,206,996,006.94	00.00	00.00	5,206,996,006.94
Тайлант үеийн үр дүн	1,474,849,925.14	00.00	47,199,920.46	00.00	1,522,049,845.60
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	47,199,920.46	00.00	6,729,045,852.54

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,149,100.00	313,772,555.57	-11,376,544.43	96.50
УРСГАЛ ЗАРДАЛ	325,149,100.00	313,772,555.57	-11,376,544.43	96.50
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,149,100.00	313,772,555.57	-11,376,544.43	96.50
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,738,100.00	83,873,925.64	-3,864,174.36	95.60
Үндсэн цалин	70,632,900.00	64,812,484.64	-5,820,415.36	91.76
Нэмэгдэл	10,175,200.00	9,372,593.00	-802,607.00	92.11
Унаа хоолны хөнгөлөлт	6,930,000.00	9,688,848.00	2,758,848.00	139.81
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,528,600.00	9,989,754.93	-538,845.07	94.88
Хангамж, бараа материалын зардал	44,474,800.00	44,428,057.00	-46,743.00	99.89
Бичиг хэрэг	16,601,400.00	16,623,099.00	21,699.00	100.13
Тээвэр, шатахуун	900,000.00	2,750,000.00	1,850,000.00	305.56
Ном, хэвлэл	6,250,000.00	6,250,000.00	0.00	100.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	20,723,400.00	18,804,958.00	-1,918,442.00	90.74
Эд хогшил, урсгал засварын зардал	108,200,000.00	107,299,488.00	-900,512.00	99.17
Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	29,876,500.00	-123,500.00	99.59
Урсгал засвар	78,200,000.00	77,422,988.00	-777,012.00	99.01
Томилолт, зочны зардал	1,775,000.00	1,732,000.00	-43,000.00	97.58
Дотоод албан томилолт	1,775,000.00	1,732,000.00	-43,000.00	97.58
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,432,600.00	48,158,420.00	-274,180.00	99.43
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,432,600.00	39,260,600.00	-172,000.00	99.56
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	8,897,820.00	-102,180.00	98.86
Бараа үйлчилгээний бусад зардал	24,000,000.00	18,290,910.00	-5,709,090.00	76.21
Бараа үйлчилгээний бусад зардал	24,000,000.00	18,290,910.00	-5,709,090.00	76.21
Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	35.00	35.00	0.00	100.00
Удирдах ажилтан	06.00	06.00	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	0.00	100.00

4.6 Аудит хийсэн төсвийн тохируулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

Хөтөлбөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Тохируулга	Хөрөнгө оруулалт
72206	80101	131003	төвлөрүүлэх шилжүүлэг	11,368,544.43	

4.7 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр:	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар”-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/135/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар”		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	<p>Байгууллагын автомашинд авсан сэлбэгийн үнэ 606.5 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн материалын зардлын дансанд бүртгэсэн</p> <p>Энэ нь Төсвийн тухай хуулийн 22.6.3 дах заалт “ Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, Сангийн сайдын 55 дугаар тушаал “ Эдийн засгийн ангилал батлах тухай”-, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар” –уудыг зөрчсөн</p>	3,356.5	Зөвлөмж өгөх	нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
	Нийт дүн	3,356.5			

